

БҮХ ХЯТАДЫН АРДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИХ ХУРЛЫН АРВАН НЭГ ДЭХ УДААГИЙН СОНГУУЛИЙН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ТУХАЙ

*Н.Төмөр**

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал /БХАТИХ/-ын арваннэг дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 2008 оны 3 дугаар сард Бээжин хотноо болов. БНХАУ-ын муж, өөртөө засах орон, хот болон Ардын чөлөөлөх армиас сонгогдсон 2987 төлөөгчид их хуралд оролцсноос ӨМӨЗО-ны 58, Гуанси жуан үндэстний өөртөө засах орны 88, ТӨЗО-ны 20, Нинся хотон үндэстний өөртөө засах орны 19, СУӨЗО-ны 60, Ардын чөлөөлөх армийн 268 төлөөлөгчид тус тус оролцжээ.

Уг чуулганд Засгийн газрын ажлын тухай тайлан илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао, Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 2007 оны төлөвлөгөөний биелэлт, 2008 оны төсвийн төслийн тухай илтгэлийг Улсын хөгжил ба өөрчлөлт шинэчлэлийн хорооны дарга Ма Кай, 2007 оны төсвийн гүйцэтгэл, 2008 оны төсвийн төслийн тухай илтгэлийг Сангийн яамны сайд Жинь Реньчин, БХАТИХ-ын Байнгын хорооны ажлын тухай тайлан илтгэлийг БХАТИХ-ын Байнгын хорооны дарга У Банго, Ардын дээд шүүхийн ажлын тухай тайлан илтгэлийг Ардын дээд шүүхийн дарга Сяо Ян, Ардын дээд прокурорын газрын ажлын тухай тайлан илтгэлийг Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокурор Жя Чуньван нар тус тус тавив.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао, Засгийн газрын ажлын тухай илтгэлдээ, БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн асуудал, гадаад бодлогын үндсэн чиглэлийн талаар тодорхой яриу. Тэрээр эдийн засагт олсон амжилтын талаар хэлэхдээ, 2007 оны байдлаар БНХАУ-ын ДНБ 24660 тэрбум юань болсноор дэлхийн дөрөвдүгээрт орох болов. Энэхүү ДНБ жилээс жилд 10.6%-иар өсөн нэмэгдэж байсан хурдцыг багасгаж 2008 онд 8%-иар өсгөх зорилт тавьжээ. Вэнь Жябао илтгэлдээ, эдийн засгийг эрчимтэй хурдтай хөгжүүлэхийн зэрэгцээ байгаль орчныг хамгаалах, агаарыг бохирдуулахгүй байх, эрчим хүчийг хэмнэх зэрэг асуудалд анхаарал тавин ажиллах нь нэн чухал гэж онцлон заажээ. Газар тариалангийн аж ахуйг цаашид улам их хөгжүүлэхийн тулд газар тариалангийн аж ахуйг удирдан зохицуулах байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон газар тариалангийн аж ахуйн их дээд сургуулиудын ажиллагааг улам бүр боловсронгуй сайжруулах шаардлагатай бөгөөд үнд 562.5 тэрбум юань зарцуулахаар төлөвлөсөн нь өнгөрсөн оныхоос 130.7 тэрбум юаниар илүү байна гэжээ. Вэнь Жябао илтгэлдээ, өнгөрсөн таван жилд тус улсын санхүү эдийн засгийн байдал сайн байсныг тэмдэглээд 2007 оны байдлаар экспорт,

* Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

импортын нийт хэмжээ 2173.8 тэрбум ам.долларт хүрснээс экспортын хэмжээ 1218 тэрбум ам.доллар, импортын хэмжээ 955.8 ам.доллар тус тус байсан бөгөөд импортын хэмжээнээс давсан экспортын хэмжээ 262.2 тэрбум ам.доллар, гадаад валютын нөөц 1528.2 тэрбум ам.доллар болсон байна гэж тэмдэглэжээ.

БНХАУ-д 2007 оны байдлаар 501.5 сая тн үр тариа, 68 сая тн мах, 24.61 сая тн тосны ургамал, 7.6 сая тн хөвөн, 2.536 тэрбум тн нүүрс, 0,187 тэрбум тн газрын тос, 3277.72 тэрбум киловат/цаг цахилгаан эрчим хүч, 489.66 сая тн болд, 23.508 сая тн өнгөт металл, 1.36 тэрбум тн цемент, 57.869 сая тн химийн бордоо, 8.887 сая ачааны машин, 4.798 сая суудлын машин, 203 мян. трактор тус тус үйлдвэрлэв гэж “БНХАУ-ын Улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн 2007 оны статистикийн мэдээ”-нд дурджээ.

Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао илтэлийнхээ гадаад бодлогын хэсэгт, “Бид биеэ даасан энхтайванч гадаад бодлогыг тууштай баримтлан, хөгжингүй орнуудтай харилцаагаа чармайн хөгжүүлж, хөрш орнуудтай сайн хөршийн найрсаг харилцаагаа бүх талаар гүнзгийрүүлэн, хөгжиж буй орнуудтай эв нэгдэл, хамтын ажиллагаагаа эрчимтэй бэхжүүлэн, олон талт гадаад харилцаагаа идэвхтэй өрнүүлнэ” гэж тэмдэглэжээ.

БХАТИХ-ын арваннэг дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар БНХАУ-ын даргаар Ху Жиньтао, дэд даргаар Си Жинпин нарыг, БНХАУ-ын Цэргийн төв зөвлөлийн даргаар Ху Жиньтао-г, БХАТИХ-ын Байнгын хорооны даргаар У Банго-г, Ардын дээд шүүхийн даргаар Ван Шэнжюнийг, Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокуророор Цао Жяньминийг тус тус сонгожээ. Ху Жиньтао, У Банго нар улиран сонгогдов.

БХАТИХ-ын арваннэг дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын даргын зарилгаар Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар Вэнь Жабао-г, Ерөнхий сайдын оролгчоор Ли Кэчян, Хуэй Лян-юй, Жан Дэжан, Ван Чишань нарыг, гишүүнээр Лю Яньдун, Лян Гуанле, Ма Кай, Мэн Жяньжу, Дай Бинго нарыг, Гадаад явдлын яамны сайдаар Ян Цэчи, Батлан хамгаалах яамны сайдаар Лян Гуанле, Улсын хөгжил ба өөрчлөлт шинэчлэлийн хорооны даргаар Жан Пин, Боловсролын яамны сайдаар Вань Ган, Сангийн яамны сайдаар Се Суйрень зэрэг 25 яамны сайд, хорооны дарга нарыг томилжээ.

БНХАУ-ын дарга Ху Жиньтао 1942 онд Аньхой мужид төрж, 1964 онд ХКН-д элсэн, 1965 онд Бээжингийн Цинхуа их сургуулийг Усны аж ахуйн барилга байгууламжийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 1985-1988 онд Гуйжоу мужийн Намын хорооны дарга, 1988-1992 онд ТӨЗО-ны Намын хорооны даргаар тус тус ажиллаж байсан. 1992-1993 онд ХКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны Байнгын хорооны гишүүнээр сонгогдон, Намын төв хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын нарийн бичгийн

даргаар томилогдон ажилласан. 1993-1998 онд Намын төв хорооны УТТ-ны Байнгын хорооны гишүүнээр сонгогдон, Намын төв хорооны дэргэдэх Намын сургуулийн захирлаар томилогдсон. 1998-1999 онд Намын төв хорооны УТТ-ны Байнгын хорооны гишүүн бөгөөд Намын төв хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын нарийн бичгийн дарга, БНХАУ-ын дэд дарга, Намын төв хорооны дэргэдэх Намын сургуулийн захирал байсан. 2002 онд Намын төв хорооны УТТ-ны Байнгын хорооны гишүүн, Намын төв хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын нарийн бичгийн дарга, ХКН-ын Төв хорооны цэргийн зөвлөлийн дэд дарга, БНХАУ-ын дэд дарга, БНХАУ-ын Цэргийн төв зөвлөлийн дэд дарга, Намын төв хорооны дэргэдэх Намын сургуулийн захирлаар тус тус ажиллаж байсан. 2002 онд ХКН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, 2003 онд БНХАУ-ын дарга, 2004 онд ХКН-ын Төв хорооны цэргийн зөвлөлийн дарга, 2007 онд ХКН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ХКН-ын Төв хорооны цэргийн зөвлөлийн даргаар тус тус сонгогджээ.

БХАТИХ-ын Байнгын хорооны дарга У Банго 1941 онд Аньхой мужид төрж, 1964 онд ХКН-д элсэн, 1967 онд Бээжингийн Цинхуа их сургуулийг Электрон вакуум тоног төхөөрөмжийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 1999-2002 онд ХКН-ын Намын төв хорооны УТТ-ны гишүүн, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогчоор, 2003-2007 онд ХКН-ын Намын төв хорооны УТТ-ны Байнгын хорооны гишүүн, БХАТИХ-ын Байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байсан.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жабао 1942 онд Тяньжин хотод төрж, 1965 онд ХКН-д элсэн, 1968 онд Бээжингийн Геологийн их сургуулийг Геологийн бүтцийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 1998-2002 онд ХКН-ын Төв хорооны УТТ-ны гишүүн, ХКН-ын Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогчоор, 2003-2007 онд ХКН-ын Намын төв хорооны УТТ-ны Байнгын хорооны гишүүн, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар тус тус ажиллаж байсан.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. “ХКН-ын 16-р их хурлын баримт бичгийн эмхэтгэл”, Бээжин, 2002
2. “ХКН-ын 16 дахь удаагийн сонгуулийн Намын төв хорооны IV Бүгд хурлын мэдээ”, Бээжин, 2004
3. “ХКН-ын 17-р их хурлын баримт бичгийн эмхэтгэл”, Бээжин, 2007
4. “БНХАУ-ын БХАТИХ-ын Арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы баримт бичгийн эмхэтгэл”, Бээжин, 2003
5. “БНХАУ-ын БХАТИХ-ын Арваннэг дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы баримт бичгийн эмхэтгэл”, Бээжин, 2008
6. “БНХАУ-ын Улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн 2007 оны статистикийн мэдээ”, Бээжин, 2008